



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 433

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 49,600,000.00 (дөчин есөн сая зургаан зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 47,947,358,69 (дөчин долоон сая есөн зуун дөчин долоон мянга гурван зуун тавин найман төгрөг жаран есөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Ховд Цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Балжинням, “Ховд цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ш.Арстан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000872

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
 433 дугаар тогтоолын хавсралт

"ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИАС "ХОВД ЦАХИРГААН ТҮГЭХ СҮЛЖЭЭ"  
 ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Моторын эзэлхүүн	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин, Лексус-470, 23-25 УНА, JTJHT00W113500194	2001/2008	4700сс	49,600,000.00	47,947,358.69	1,652,641.31
Нийт дүн				(дөчин есөн сая зургаан зуун)	(дөчин долоон сая есөн зуун дөчин долоон мянга гурван зуун тавин найман төгрөг жаран есөн мөнгө)	(нэг сая зургаан зуун тавин хоёр мянга зургаан зуун дөчин нэгэн төгрөг гучин нэгэн мөнгө)